



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 дугаар сарын 14

№ 01/32 АУА-2018/25/СТА -ТЦ/З Мандаговь хот

Г Зөрчлийг арилгуулах тухай

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Хулд сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийх явцад Сангийн хөрөнгөөс 16,700,000.00 /арван гурван сая долоон зуун мянга/ төгрөгийг сумын иргэд олон нийтийн саналыг аваагүй, жагсаалтаар эрэмбэлгээгүй, зориулалт бус “*Цагдаагийн авто машин, цагдаагийн торгуулийн посс машин*” зардалд зарцуулсан.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.5.-д /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/, 60 дугаар зүйлийн 60.3-т /Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно/, 60.3.1.-д /орон нутгийн төсвийг санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөөшөр, арга хэмжээ/, 60.3.6-д /орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ/ заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /*Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хуувь тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих*/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтийг эрх үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /*Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжсээ, аудитор, шинжсээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгумах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх*/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.3-т /*Төсвийн хөрөнгийн үр ашиггүй, зориулалт бусаар батлагдсан хэмжэээнээс хэтрүүлэн зарцуулэх, Төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн*;/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2018 онд Төсвийн тухай хуулийн шаардлагыг хангаагүй, зориулалтын бус зардалд зарцуулахаар төлөвлөсөн хөрөнгө оруулалт, тесөл арга хэмжээг жагсаалтаас хасч тодотгох,

Албан шаардлагын биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт албан ёсоор ируулэхийг Хулд сумын Засаг дарга Ч.Зоригтбаатар, нягтлан бодогч Ч.Хүүхэнбаатар нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН:  АХЛАХ АУДИТОР Д.ИХБАЯР 4817144213 ЗЮА0039 9033475	ЗӨВШӨӨРСӨН:  ЗАСАГ ДАРГА Ч.ЗОРИГТБААТАР НЯГТЛАН БОДОГЧ Ч.ХҮҮХЭНБААТАР
--	---

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хургуулна" гэж заасны дагуу хариуцаач албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хургуулна.